



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ОРА-2023/57/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Орхон аймаг  
2024 он

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: Ц.Нармандах  
Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Буян-ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: Buynundrakhb@audit.gov.mn

Аудитор: Ж.Наранчимэг  
Утас: 70359826 Цахим хаяг: naranchimegj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.08.26 № 71  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН МЭДЭЭЛЭЛ  
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН  
ТӨВ УТҮГ-ЫН ЗАХИРАЛ  
Н.ГАНСҮХ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГазар нь орон нутгийн төсвөөс 237,559.6 мянган төгрөгийн санхүүжилт авснаас 2,324.1 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 99.0 хувьтай байна.

**Аудитын гол асуудал**

Тайлант онд хөрөнгө оруулалтаар 843,773.3 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй орлогоор хүлээн авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Орхон аймгийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв УТҮГазар 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөрийн хүрээнд 3 зорилт, 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр Орхон аймгийн Засаг даргатай байгуулж хэрэгжилтийг хангалттай гэж үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй төрийн аудитын албан хаагчид аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>62,529,983.00</b>	<b>60,398,984.80</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	62,529,983.00	60,398,984.80
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	25,064,236.00	21,211,400.00
35110	Тусгай зориулалттай материал	25,064,236.00	21,211,400.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	37,465,747.00	39,187,584.80
35410	Бичиг хэргийн материал	355,000.00	602,000.00
35420	Аж ахуйн материал	26,200.00	135,600.00
35430	Сэлбэг хэрэгсэл	36,404,547.00	36,043,803.00
35440	Түлш, шатах тослох материал	680,000.00	2,406,181.80
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,677,220,261.51</b>	<b>2,748,857,296.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,677,220,261.51	2,748,857,296.31
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,617,918,795.67	2,723,943,229.91
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,900,000.00	5,900,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(983,333.20)	(1,278,333.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	-	87,915,410.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	(13,187,311.47)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,111,535,697.00	3,737,047,015.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(924,282,954.87)	(1,571,135,790.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	46,532,857.00	43,357,057.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(11,866,950.07)	(15,144,055.67)
39214	Бусад үндсэн хөрөнгө	490,715,970.00	621,062,580.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(99,632,490.19)	(170,593,340.94)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	59,301,465.84	24,914,066.40
39301	Програм хангамж	88,100,000.00	88,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(58,733,333.20)	(76,353,333.16)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,069,598.00	67,069,598.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(37,134,798.96)	(53,902,198.44)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,739,750,244.51</b>	<b>2,809,256,281.11</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,739,750,244.51</b>	<b>2,809,256,281.11</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,739,750,244.51	2,809,256,281.11
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,739,750,244.51	2,809,256,281.11
51210	Өмнөх үеийн үр дүн	2,739,750,244.51	2,739,750,244.51
51220	Тайлант үеийн үр дүн	-	69,506,036.60
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,739,750,244.51</b>	<b>2,809,256,281.11</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,477,395,835.00</b>	<b>1,091,758,119.80</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,331,177,435.00</b>	<b>843,779,519.80</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,331,177,435.00	843,779,519.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,331,177,435.00	843,779,519.80
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,293,052,938.00	843,773,338.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	38,124,497.00	6,181.80
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>146,218,400.00</b>	<b>247,978,600.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,620,000.00	10,419,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,620,000.00	10,419,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	133,598,400.00	237,559,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	133,598,400.00	237,559,600.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>710,221,155.06</b>	<b>1,020,425,998.20</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>710,221,155.06</b>	<b>1,020,425,998.20</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	709,089,262.26	1,016,901,854.18
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	91,558,962.00	155,391,543.00
210101	Үндсэн цалин	78,980,615.00	119,016,660.00
210102	Нэмэгдэл	11,780,671.00	25,711,734.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,649,000.00
210104	Урамшуулал	797,676.00	8,014,149.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,444,874.71	19,423,936.52
210201	Тэтгэврийн даатгал	7,782,512.05	13,208,281.36
210202	Тэтгэмжийн даатгал	915,589.62	1,553,909.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	732,471.73	1,243,131.32
210204	Ажилгүйдлийн даатгал	183,122.07	310,783.05
210205	Эрүүл мэндийн даатгал	1,831,179.24	3,107,830.86
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,949,352.61	18,659,773.33
210301	Гэрэл, цахилгаан	13,290,260.66	16,930,361.74
210302	Түлш, халаалт	1,102,811.86	1,200,571.90
210303	Цэвэр, бохир ус	438,780.09	528,839.69
210304	Байрны түрээс	2,117,500.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,028,417.88	32,618,119.13
210401	Бичиг хэрэг	864,750.00	1,110,500.00
210402	Тээвэр, шатахуун	750,000.00	1,420,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,446,717.88	7,387,646.13
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	169,500.00	349,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,797,450.00	2,443,637.00
210408	Бараа материал акталсны зардал	-	19,906,836.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,719,950.00	18,010,744.00
210604	Урсгал засвар	1,719,950.00	18,010,744.00

2107	Томилолт, зочны зардал	250,000.00	499,600.00
210702	Дотоод албан томилолт	250,000.00	499,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,000,000.00	1,987,920.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	1,987,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	577,137,705.06	770,310,218.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	577,137,705.06	770,310,218.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,131,892.80	3,524,144.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,200,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,200,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	131,892.80	2,324,144.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,892.80	2,324,144.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<b>1,767,174,679.94</b>	<b>71,332,121.60</b>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	1,826,085.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,826,085.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(1,826,085.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>1,767,174,679.94</b>	<b>69,506,036.60</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>146,218,400.00</b>	<b>248,024,100.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>146,218,400.00</b>	<b>248,024,100.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,620,000.00	10,419,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,620,000.00	10,419,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	133,598,400.00	237,559,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	133,598,400.00	237,559,600.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	-	45,500.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	45,500.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>146,218,400.00</b>	<b>248,024,100.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>146,218,400.00</b>	<b>248,024,100.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>145,086,507.20</b>	<b>244,454,455.98</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	91,558,962.00	155,391,543.00
210101	Үндсэн цалин	78,980,616.00	119,016,660.00
210102	Нэмэгдэл	11,780,670.00	25,711,734.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	2,649,000.00
210104	Урамшуулал	797,676.00	8,014,149.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	11,444,874.71	19,423,936.52

210201	Тэтгэврийн даатгал	7,782,512.05	13,208,281.36
210202	Тэтгэмжийн даатгал	915,589.62	1,553,909.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	732,471.73	1,243,131.32
210204	Ажилгүйдлийн даатгал	183,122.07	310,783.05
210205	Эрүүл мэндийн даатгал	1,831,179.24	3,107,830.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,949,352.61</b>	<b>18,659,773.33</b>
210301	Гэрэл, цахилгаан	13,290,260.66	16,930,361.74
210302	Түлш, халаалт	1,102,811.86	1,200,571.90
210303	Цэвэр, бохир ус	438,780.09	528,839.69
210304	Байрны түрээс	2,117,500.00	-
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>10,263,317.88</b>	<b>16,292,683.13</b>
210401	Бичиг хэрэг	862,750.00	2,482,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	3,140,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,446,717.88	7,387,646.13
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	169,500.00	349,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,584,350.00	2,933,037.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>-</b>	<b>1,000,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,620,000.00</b>	<b>31,199,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,620,000.00	999,000.00
210604	Урсгал засвар	-	30,200,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>250,000.00</b>	<b>499,600.00</b>
210702	Дотоод албан томилот	250,000.00	499,600.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,987,920.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	1,987,920.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,131,892.80</b>	<b>3,569,644.02</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>	<b>1,245,500.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	45,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,200,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>131,892.80</b>	<b>2,324,144.02</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,892.80	2,324,144.02
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,739,750,244.51	2,739,750,244.51
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,739,750,244.51	2,739,750,244.51

D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,739,750,244.51	2,739,750,244.51
D08	Тайлант үеийн үр дүн	69,506,036.60	69,506,036.60
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,809,256,281.11	2,809,256,281.11

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 4.5 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Байгууллага Сод Монголын ШТС-аас картаар шатахуун авдаг ба картын урамшуулал болох 4,545 төгрөгийг 3-р улирлын тайланд тусгаагүй байсныг жилийн эцсийн тайланд үнэ төлбөргүй орлогоор бүртгэсэн байна.
- Байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд үлдэгдэл зөрүүтэй, нярав бараа материалыг зарлагдахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу байсныг бүрэн хэрэгжүүлсэн байна.
- Шилэн дансны цахим системд бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 136,721.6 мянган төгрөгийн "Хөрөнгө орлогод авах тухай" тушаалыг мэдээлээгүй, орхигдуулж мэдээлснийг нөхөн мэдээлсэн байна.

Аудитаар нийт 415.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар залруулаагүй 1 зөрчилтэй асуудал нь тогтоосон материаллаг байдлын дүнгээс бага байгаа тул өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн болно.

### 3.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 3.2 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөөгүй.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Ажил гүйлгээний анги-Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:** Тайлант онд урсгал зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал болон бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 415.0 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах” гэсэн заалт, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 2-ний өдрийн 190 дугаар тушаалаар баталсан төсвийн зардлын ангилалтай нийцэхгүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллага Сод Монголын ШТС-аас картаар шатахуун авдаг ба картын урамшуулал болох 4545 төгрөгийг 3-р улирлын тайланд тусгаагүй	1	4.5	1	4.5			1	4.5				
Байгууллагын бараа материалын үлдэгдэлд түүвэрлэн биет тооллого хийхэд үлдэгдэл зөрүүтэй, нярав бараа материалыг зарлагдахдаа анхан шатны баримтын бүрдэл дутуу	1	0			1	0	1	0				
Шилэн дансны цахим системд бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 136,721.6 мянган төгрөгийн "Хөрөнгө орлогод авах тухай" тушаалыг мэдээлээгүй, орхигдуулж мэдээлсэн	1	0	1	0			1	0				
Дүн	3	4.5	2	4.5	1	0	3	4.5				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтн ы тоо	Тоо	Дүн
Урсгал зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал болон бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 415.0 мянган төгрөгийг бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан байна.	1	415.0					1	415.0				
Дүн	1	415.0					1	415.0				